

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 28 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/93/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
Shinjlenmagadlahui.
audit@gmail.com
Улаанбаатар хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр
Утас: 70373089, 99023682
Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn
Аудитын менежер: У.Батсүрэн
Утас: 99036806 Цахим хаяг: Batsurenu@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: 99377479 Цахим хаяг: Battsetsegs@audit.gov.mn
Аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК
Утас: 99197346, 88114867 Цахим хаяг:
Shinjlenmagadlahui.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг	4
Дархан-Уул аймгийн Шарын гол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь сонгуулийн жилтэй холбоотой 9 дахь удаагийн бүрэн эрхийн анхдугаар хуралдаан болж, 23 төлөөлөгч сонгогдон тэмдэг, үнэмлэхээ гардан авсан байна.	4
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	18
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гарсан алдаа, зөрчилтэй асуудал байхгүй.	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.5.1 Завсрын аудитын талаар	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Төлбөрийн акт	21
Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.	21
5.2 Албан шаардлага	21
5.3 Зөвлөмж	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
28 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.БАТ-ӨЛЗИЙ ТАНАА**

2025.02.25 № 110
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 28 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Дархан-Уул аймгийн Дархан сумын 28 дугаар цэцэрлэгийн 2024 оны нийт төсвийн зарцуулалт тайлант онд хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 90.9 хувийн биелэлттэй байна.

2024 онд нэг хүүхдэд ногдох хувьсах зардалтай холбоотойгоор 12 сард санхүүжилтийг цалин, хоолны зардал дээр 82,989.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн өгсөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

4525020139

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр тус цэцэрлэгийн цалингийн зардал 556,205.7 мянган төгрөг болж өнгөрсөн оны гүйцэтгэлээс 36,3 хувиар өссөн байна

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Дархан сумын 28 дугаар цэцэрлэг нь байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд ажлаа төлөвлөж, хэрэгжилт нь 100.0 хувийн биелэлттэй ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	80,184,362.84	153,149,225.87
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	71,255,381.90	140,255,360.12
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	71,255,381.90	140,255,360.12
3121	Төгрөг	71,255,381.90	140,255,360.12
31211	Төрийн сангийн харилцах	71,255,381.90	140,255,360.12
35	БАРАА МАТЕРИАЛ	8,928,980.94	12,893,865.73
351	Түүхий эд материал	-	90,000.00
35130	Эм боох материал	-	90,000.00
354	Хангамжийн материал	8,928,980.94	12,803,865.75
35410	Бичиг хэргийн материал	-	211,000.00
35420	Аж ахуйн материал	-	1,200,000.00
35460	Хүнсний материал	8,928,980.94	8,837,565.75
35470	Бусад хангамжийн материал	-	2,555,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	806,407,658.28	896,361,464.22
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	806,407,658.28	896,361,464.22
392	Биет хөрөнгө	681,058,491.77	771,242,297.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	714,952,264.77	792,172,870.77
39202	Хуримтлагдсан элэгдэл	(71,078,105.88)	(96,151,909.19)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	44,335,572.30	66,211,476.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(25,378,176.14)	(17,963,995.82)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,861,085.82	37,683,845.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,788,032.17)	(11,888,984.83)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,766,274.70	-
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,791,386.63)	-
39217	Ном	1,178,995.00	1,178,995.00
393	Биет бус хөрөнгө	125,349,166.51	125,119,166.47
39301	Програм хангамж	1,150,000.00	1,150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(900,833.49)	(1,130,833.53)
39303	Бусад биет бус хөрөнгө	125,100,000.00	125,100,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	886,592,021.12	1,049,510,690.09
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	886,592,021.12	1,049,510,690.09
51	Засгийн газрын хувь оролцоо	886,592,021.12	1,049,510,690.09
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	886,592,021.12	1,049,510,690.09
51210	Өмнөх үеийн үр дүн	886,592,021.12	886,592,021.12
51220	Тайлант үеийн үр дүн	-	162,918,668.97
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	886,592,021.12	1,049,510,690.09

ХТ05430 @ 9022599

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	655,383,563.00	970,293,166.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,031,663.00	122,952,266.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,031,663.00	122,952,266.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,300,000.00	15,213,360.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,300,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	15,213,360.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан Үндсэн Хөрөнгө	3,533,663.00	107,738,906.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан Бараа материал	198,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	649,351,900.00	847,340,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	625,326,300.00	806,576,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	625,326,300.00	806,576,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,025,600.00	40,764,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,025,600.00	40,764,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	613,676,438.14	807,374,497.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	613,676,438.14	807,374,497.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	606,012,422.39	805,280,620.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	408,090,020.14	556,205,739.00
210101	Үндсэн цалин	278,207,567.47	385,216,916.24
210102	Нэмэгдэл	114,262,663.22	141,200,037.81
210104	Урамшуулал	15,619,789.45	29,788,784.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,423,562.89	69,982,522.78
210201	Тэтгэврийн даатгал	36,477,253.29	47,727,076.88
210202	Тэтгэмжийн даатгал	4,317,314.25	5,721,251.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,388,309.34	2,950,286.74
210204	Ажилгүйдлийн даатгал	839,488.10	2,718,365.31
210205	Эрүүл мэндийн даатгал	8,401,197.91	10,865,542.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,725,484.25	27,170,904.11
210301	Гэрэл, цахилгаан	7,647,358.80	10,380,881.50
210302	Түлш, халаалт	8,578,465.37	8,473,360.28
210303	Цэвэр, бохир ус	6,499,660.08	8,316,662.33
2104	Хангамж, бараа материалын зардал	7,518,150.00	13,045,510.00
210401	Бичиг хэрэг	3,475,000.00	2,044,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,663,950.00	10,439,040.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,379,200.00	561,670.00
2105	Нормативт зардал	68,992,625.06	86,926,835.19
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	111,700.00	760,760.00

210502	Хоол, хүнс	68,880,925.06	86,166,075.19
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,498,000.00	4,232,419.00
210604	Урсгал засвар	2,498,000.00	4,232,419.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,179,100.00	2,611,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,179,100.00	2,611,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,585,480.05	45,105,390.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,730,930.00	7,174,230.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	34,854,550.05	37,931,160.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,664,015.75	2,093,876.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,663,900.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,663,900.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	115.75	2,093,876.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	115.75	2,093,876.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	41,707,124.86	162,918,668.97
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	41,707,124.86	162,918,668.97




2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	651,651,900.00	847,340,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,300,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	2,300,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,300,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,300,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	649,351,900.00	847,340,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	625,326,300.00	806,576,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	625,326,300.00	806,576,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,025,600.00	40,764,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,025,600.00	40,764,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	577,726,251.03	773,408,221.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	577,726,251.03	773,408,221.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	570,062,235.28	771,314,344.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	408,090,020.14	556,205,739.00
210101	Үндсэн цалин	278,207,567.47	385,216,916.24
210102	Нэмэгдэл	114,262,663.22	141,200,037.81
210104	Урамшуулал	15,619,789.45	29,788,784.95
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,423,562.89	69,982,522.78
210201	Тэтгэврийн даатгал	36,477,253.29	47,727,076.88
210202	Тэтгэмжийн даатгал	4,317,314.25	5,721,251.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,388,309.34	2,950,286.74
210204	Ажилгүйдлийн даатгал	839,488.10	2,718,365.31
210205	Эрүүл мэндийн даатгал	8,401,197.91	10,865,542.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,725,484.25	27,170,904.11
210301	Гэрэл, цахилгаан	7,647,358.80	10,380,881.50
210302	Түлш, халаалт	8,578,465.37	8,473,360.28
210303	Цэвэр, бохир ус	6,499,660.08	8,316,662.33
2105	Нормативт зардал	68,973,488.00	86,074,660.00
210502	Хоол, хүнс	68,973,488.00	86,074,660.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,300,000.00	9,499,919.00
210604	Урсгал засвар	1,300,000.00	9,499,919.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,179,100.00	2,611,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,179,100.00	2,611,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,370,580.00	19,769,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,833,380.00	11,858,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,537,200.00	7,910,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,664,015.75	2,093,876.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,663,900.00	-

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,663,900.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	115.75	2,093,876.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	115.75	2,093,876.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	73,925,648.97	73,932,678.22
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,726,105.00	4,932,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,726,105.00	4,932,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,726,105.00	4,932,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,726,105.00	4,932,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(7,726,105.00)	(4,932,700.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	66,199,543.97	68,999,978.22
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,055,837.93	71,255,381.90
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	71,255,381.90	140,255,360.12



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан / төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	844,884,896.26	844,884,896.26
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	844,884,896.26	844,884,896.26
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	41,707,124.86	41,707,124.86
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	886,592,021.12	886,592,021.12
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	886,592,021.12	886,592,021.12
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	886,592,021.12	886,592,021.12
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	162,918,668.97	162,918,668.97
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,049,510,690.09	1,049,510,690.09



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	925,130,500.00	776,247,044.89	(148,883,455.11)	87.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	925,130,500.00	776,247,044.89	(148,883,455.11)	87.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	925,130,500.00	776,247,044.89	(148,883,455.11)	87.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	677,137,100.00	556,205,739.00	(120,931,361.00)	82.14
210101	Үндсэн цалин	484,337,000.00	385,216,916.24	(99,120,083.76)	79.53
210102	Нэмэгдэл	181,896,200.00	141,200,037.81	(40,696,162.19)	77.63
210104	Урамшуулал	10,903,900.00	29,788,784.95	18,884,884.95	273.19
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,258,100.00	69,982,522.78	(8,275,577.22)	89.80
210201	Тэтгэврийн даатгал	53,217,000.00	47,727,076.88	(5,489,923.12)	90.17
210202	Тэтгэмжийн даатгал	6,259,000.00	5,721,251.42	(537,748.58)	90.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,130,000.00	2,950,286.74	(179,713.26)	89.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,130,300.00	2,718,365.31	(411,634.69)	88.14
210205	Эрүүл мэндийн даатгал	12,521,500.00	10,865,542.43	(1,655,957.57)	88.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,799,000.00	27,170,904.11	(8,628,095.89)	75.89
210301	Гэрэл, цахилгаан	13,144,100.00	10,380,881.50	(2,763,218.50)	78.97
210302	Түлш, халаалт	12,080,600.00	8,473,360.28	(3,607,239.72)	70.14
210303	Цэвэр, бохир ус	10,574,300.00	8,316,662.33	(2,257,637.67)	78.65
2105	Нормативт зардал	91,525,800.00	86,074,660.00	(5,451,140.00)	94.00
210502	Хоол, хүнс	91,525,800.00	86,074,660.00	(5,451,140.00)	94.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,500,000.00	11,499,919.00	(81.00)	99.99
210604	Урсгал засвар	11,500,000.00	11,499,919.00	(81.00)	99.99
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,614,200.00	2,611,300.00	(2,900.00)	99.89
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,614,200.00	2,611,300.00	(2,900.00)	99.89
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,296,300.00	22,702,000.00	(5,594,300.00)	80.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,385,600.00	14,791,300.00	(5,594,300.00)	72.56
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,910,700.00	7,910,700.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	853,875,200.00	845,247,023.11	8,628,176.89	98.99

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	806,576,200.00	806,576,200.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	806,576,200.00	806,576,200.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	47,299,000.00	38,670,823.11	8,628,176.89	81.76
132001	Орон нутгийн төсвөөс	47,299,000.00	38,670,823.11	8,628,176.89	81.76
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	71,255,300.00	-	(71,255,300.00)	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	71,255,300.00	-	(71,255,300.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	71,255,381.90	71,255,381.90	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	140,255,360.12	140,255,360.12	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00	-	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	150.00	187.00	37.00	124.67
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	150.00	187.00	37.00	124.67
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	150.00	187.00	37.00	124.67
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.00	25.00	-	100.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	15.00	15.00	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй байна.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Дархан сумын 28 дугаар цэцэрлэг нь "Хүүхдийн нийгэм, сэтгэл зүй, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, боловсрол эзэмшихэд тулгарч буй бэрхшээлийг арилгаж сурах тэгш боломж бүрдүүлэх, хувь хүний онцлогт нийцүүлэн сургалт, үйл ажиллагааг чанар үр дүнтэй зохион байгуулах, хамтран суралцах арга барилыг сургалтад нэвтрүүлэх" гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхдийн зан чанар харилцаа, нийгэмшихүйн чадварууд, зураг дүрс, тэмдэгт мэдээллийн утга санааг ойлгон тайлбарлах чадваруудыг өдөр тутамд үлгэр, зохиолтой танилцуулах, зохиомжлон ярих, зохион бүтээлгэх зэрэг бүтээлч үйлээр дэмжих;
- Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдал, явцын үнэлгээнд суурилан тохируулга, дэмжлэгийг оновчтой тодорхойлж төсөлд суурилсан, тоглоомд суурилсан хүүхэд төвт сургалтын арга зүйг баримтлан хүүхэд өөрөө мэдлэг бүтээгч, өөрөө орчноо бүтээгч байхад чиглэсэн бүтээлч үйлээр хэрэгжүүлэх;
- Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг мэргэжлийн бүлгийн хамтын ажиллагааны хүрээнд дэмжихийн зэрэгцээ суралцагчийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн сургалт үйл ажиллагааны бэлтгэлийг хамтын оролцоотой чанартай ханган үр дүнтэй хэрэгжүүлэх;
- Багш, ажилтны бүтээлч үйл ажиллагаа, мэргэжлийн бие даасан байдлыг хүндэтгэн, хүүхдийн бүтээлчээр сурч хөгжих ээлтэй, эрүүл, аюулгүй, хүртээмжтэй, сэтгэлзүйн таатай орчныг бүрдүүлэхэд цэцэрлэг, эцэг эх асран хамгаалагч талуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлсэн, ёс зүйн хэм хэмжээт байгууллагын соёлыг төлөвшүүлэх;
- Хүүхэд бүрийг эрүүл ахуйн зөв дадал хэвшлийг эзэмших, болзошгүй эрсдлээс өөрийгөө хамгаалах чадварт суралцахад дэмжих сургалтын олон хувилбарт арга хэлбэрүүдийг хэрэгжүүлэх;
- Хүүхдийг шим тэжээллэг хоол хүнсийг хэрэглэх, эрүүл зөв хооллолтын зохистой дадал хэвшилд сургах ажлыг өдөр тутамд хэрэгжүүлэх, хоол үйлдвэрлэлийн чанарыг тогтмол сайжруулах;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 06 сарын 21-ний өдрийн “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох” тухай 240, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241-р тогтоолуудыг мөрдөж ажилласан.
- Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн журам шинэчлэн батлах тухай” тушаалыг 2024 оны 01 сарын 01-ны өдрөөс мөрдөж ажиллах
- Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 12 дугаар тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх

- Монгол улсын Засгийн газрын 2024.03.27 өдрийн тогтоол, Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 128, 2024.12.25 Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 238-р тогтоолуудыг мөрдөж ажилласан.
- Хөдөлмөр нийгмийн хамгаалын сайдын 2021.12.06 тушаал, Дундаж цалин хөлс тодорхойлох журам А/192 тогтоолыг 2022.01.01 өдрөөс мөрдөж ажиллах
- Монгол улсын Засгийн газрын 2024.02.28 тогтоол, Тогтоолд хавсралт нэмж, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай 84 тогтоолыг 2024.04.01 өдрөөс мөрдөж ажиллах
- Сангийн сайдын 2023.12.25 тушаал, Төрийн болон орон нутгийн өмчийн херенгеер бараа үйлчилгээ худалдан авах журамж шинэчлэн А/250 тогтоолыг 2023.12.25 өдрөөс мөрдөж ажиллах
- Монгол улсын Нийгмийн даатгалын ерөнхий хууль 2024.01.01 өдрөөс мөрдөж ажиллах
- Монгол улсын Засгийн газрын 2024.01.03 өдрийн 02 тогтоол, Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай 2024.01.03 өдрөөс мөрдөж ажиллах
- Монгол улсын Сангийн сайдын 2024.03.27 тушаал, Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай А/52 тогтоолыг 2024.04.01 өдрөөс мөрдөж ажиллах

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймаг Дархан сумын 28 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд 2020 онд баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж өөрийн байгууллагын онцлог нөхцөлд тулгуурлан хууль эрх зүйн орчин болон, үйл ажиллагааныхаа хүрээнд нэмэлт өөрчлөлтүүдийг тушаал гарган хавсаргасан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Дархан сумын 28 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн цалин хөлсний бодлогод МУ-ын ЗГ-ын тогтоолын дагуу өөрчлөлт орсон

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 162,918.6 мянган төгрөгөөр буюу 18.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	71,255.3	140,255.3	68,999.9
Авлага	-	-	-
Бараа материал	8,928.9	12,893.9	3,965.0
Үндсэн хөрөнгө	806,407.7	896,361.4	89,953.7
Нийт хөрөнгө	886,592.0	1,049,510.6	162,918.6
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	886,592.0	1,049,510.6	162,918.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	886,592.0	1,049,510.6	162,918.6

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь 140,255.3 мянган төгрөг болж өмнөх оноос 68,999.9 мянган төгрөгөөр өссөн нь тухайн байгууллагын цалингийн сангаас 120,931.4 мянган төгрөг, Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 8,275.6 мянган төгрөг, Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 8,628.1 мянган төгрөг, хүүхдийн хоол хүнсний зардлаас 5,451.2 мянган төгрөг, Бараа үйлчилгээний бусад зардлаас 5,594.3 мянган төгрөгийг хэмнэж Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7-д “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 12,893.8 мянган төгрөг болж 3,965.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 2,255.8 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 5,601.4 мянган төгрөгийн барилгын засварын материал, 86,074.6 мянган төгрөгийн хүнсний материал, 850.7 мянган төгрөгийн эм боох материал, 10,217.1 мянган төгрөгийн аж ахуйн бараа материалыг орлогоор бүртгэж авсан ба үйл ажиллагаанд 104,204.7 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 896,361.4 мянган төгрөг болж 89,953.7 мянган төгрөгөөр өссөн нь 73,820.6 мянган төгрөгийн барилгын хүчитгэл хийлгэж капиталжуулсан, 15,213.6 мянган төгрөгийн хөрөнгөнд дахин үнэлгээ хийж ашиглалтын хугацааг сунгасан нь шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,049,510.6 мянган төгрөг болж 162,918.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 679,561.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 53,377.2 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 0 мянган төгрөг, нийт зарлагыг 732,938.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаар тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн зардлыг 20,205.7 мянган, орон нутгаас санхүүжих зардлыг 6,078.2 мянган төгрөгөөр бууруулж, улсын төсвийн санхүүжилтийг 659,355.6 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 47,299.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь 2024 оны төсвийн төслийг Засгийн газрын тогтоолоор цалин хөлс нэмэгдсэн, гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал олгосон, хүүхэд хамгааллын зардал, хүүхдийн хоолны зардал, нөхөн хангалтын зардал батлагдсан зэргээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 147,220.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71801 хөтөлбөрийн 81834, 81835, 81807 арга хэмжээг санхүүжүүлэхээр 806,576.2 мянган төгрөгийг, 80111 арга хэмжээг санхүүжүүлэхээр 47,299.0 мянган төгрөг орон нутгийн төсвөөс, 0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 806,576.2 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 40,764.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого төвлөрүүлээгүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 776,247.1 мянган төгрөг буюу 83.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 140,255.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас хэмнэлт үүссэнтэй холбоотой байна. Орон нутгийн төсвөөс 8,628.1 мянган төгрөгийн санхүүжилт дутуу, хэмнэлт үүссэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81834-Боловсролын стандарт, сургалтын орчин	767,003.4	636,269.3	(130,734.0)	82.96
2	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	10,161.8	9,298.1	(863.7)	91.5
3	81807-Хоол хүнс	91,525.8	86,074.7	(5,451.1)	94.04
4	81605-Эрүүл мэндийг дэмжих	3,181.0	1,038.0	(2,143.0)	32.63
5	80233- Хүүхэд хамгаалал	1,255.4	1,255.4	-	100.0
6	81823-Боловсролын байгууллагын багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	1,771.4	708.0	(1,063.4)	39.97
7	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	47,299.0	38,670.9	(8,628.1)	81.7
8	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,932.7	2,932.7	-	100.0
	Дүн	925,130.5	776,247.1	148,883.4	83.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тус цэцэрлэгээс өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад байхгүй тул ахмадын сан үүсгээгүй байна. 2024 онд 65,594.3 мянган төгрөгийн хоол хүнсний материал худалдан авахаар харьцуулалтын аргаар тендер 7 удаа зарласан боловч оролцогчгүй амжилтгүй болсон. Хоол хүнсний худалдан авалтыг үнийн харьцуулалтын аргаар шууд гэрээ байгуулан ажилласан.

Төсвөөс 2024 онд зарцуулсан бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж /210801/ зардал байхгүй.

Багшийн эрүүл мэндийн үзлэг шинжилгээ, багшийн сургалтын зардал, ариутгал цэвэрлэгээний бодис худалдан авах, дотоод албан томилолт, бага үнэтэй түргэн элэгдэх зардал, бичиг хэрэг, интернэтийн зардал, аудит, төлбөр хураамжийн зардлууд багтсан ба нийт 13,391.3 мянган төгрөгийг 210901-ээс зарцуулсан.

2024 онд 25 орон тоо батлагдсан ба орон тоонд өөрчлөлт гараагүй болно.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ байхгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөрийн арга хэмжээ хэрэгжээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

2024 онд 79,795.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны 5 төсөл боловсруулж төлөвлөсөн. Хоол хүнсний 65,174.7 мянган төгрөгийн тендер харьцуулалтын аргаар 5 удаа зарласан боловч нэг ч оролцогчгүй, амжилтгүй болсон. Хоол хүнсний материал нийлүүлэх компаниудаас үнийн санал авч харьцуулалтын аргаар шууд худалдан авах хийх гэрээг Амгалан монгол ногоо ХХК, Өег гурил ХХК, Тавантойн ХХК, Цэцэн марал ХХК, Арцат алтайн уулс ХХК хийсэн. Мэдээлэл технологийн зардал 1,178.6 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн зардал 3,537.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 8,135.4 мянган төгрөг, эрүүл мэндийн зардлаас 398.0 мянган төгрөг, хоол хүнсний зардлаас 68,973.5 мянган төгрөгийг шууд худалдан авалтаар тус тус зарцуулсан.

4. АУДИТЫН ТАЙЛАН

34.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 28 дугаар цэцэрлэгийн

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах санхүүгийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит” ХХК-ийн аудитор Б.Хоролбат гүйцэтгэж, Анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Магсаржалам, гүйцэтгэх захирал С.Оргил нар дараагийн шатны чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 28 дугаар цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит” ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлан дахь нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардал 613,676.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 12,273.5 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй хэмнэлттэй ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамааруулан шалгалаа.

Дархан-Уул аймгийн 28 дугаар цэцэрлэг нь 2024 онд мэдээлбэл зохих 169 мэдээллийн хуульд заасан хугацаанд бүрэн байршуулсан байгаа тул шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гарсан алдаа зөрчилтэй асуудал байхгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дархан-Уул аймгийн Дархан сумын 28 дугаар цэцэрлэгийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нэг хүүхдэд ноогдох хоолны махны нормыг 2,242.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан зөрчил илэрч, төлбөрийн акт тогтоосон, цаашид үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах 2 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилтийг шалгахад 100.0 хувь хэрэгжсэн байна

Хүснэгт 4 зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	3,833.7	1	3,833.7	100.0
акт	1	2,242.3	1	2,242.3	100.0
Нийт дүн	3	6,076.0	3	6,076.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

2024 оны эцэст төвлөрүүлсэн цалингийн зардал 120,168.8 мянган төгрөг ба батлагдсан орон тоо 2024 оны 12 дугаар сарын 25-нд 25 ажилчин албан хаагчидтай ажилласан. Нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаар тооцож цалингийн санг оны эцэст 75,280.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж санхүүжилтийг олгосон нь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өсөхөд нөлөөлжээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлагналтай холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.